



“ЦЭСБ-АУДИТ” ХХК

Дархан-Уул аймаг, Дархан сум
10-р баг, 5-р хороолол, “ЛХА”
ХХК-ий байр 01 тоот
Утас/факс: 95112689, 99352099
И-мэйл: Ts_nadii@yahoo.com

2022.02.08, № 18

танай _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “АСБИ” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, шударгаар толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг АОУС-уудын дагуу хийж гүйцэтгэхдээ компаниас хараат бусаар ажиллаж, мэргэжлийн ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайланд ба аудиторын тайланд багтаагүй мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй тул бид бусад мэдээлэлд баталгаажуулалт гаргахгүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах, компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих, ННБ-ийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэх үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний хүлээх үүрэг хариуцлага бол өөрсдийн гүйцэтгэсэн аудитад тулгуурлан компанийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах явдал юм.

ЗАХИРАЛ



Ч.ЦЭРЭННАДМИД (МНБ)